

ХҮРЭЭ, КОНСУЛЫН ДЭНЖИЙН НУУЦ БҮЛГЭМҮҮДИЙН НЭГДСЭН ҮЙЛ ЯВЦ (1918-1921)

А.Алтанбагана

Товч утга: Дундад Иргэн Улсын Гадаад Монголын автономит эрхийг устгах алхмууд Нийслэл Хүрээнд үүсээд байсан тангарагт нөхөд (улмаар Хүрээний бүлгэм болж өргөжссөн) Консулын дэнжийн нууц бүлгэмүүд хооронд холбоо тогтоож улсынхаа бие даасан байдлыг хамгаалах үйлсэд хамтран тэмцэх болсон байна. Харин тэдний нийгэм-улс төрийн болоод намын талаарх үзэл бодол харилцан адилгүй байсан зэрэг шалтгаануудаас үзвэл нууц бүлгэмүүд нэгдэж улс төрийн нам байгуулахад бэлэн биш байв. Нууц бүлгэмд харъяалагдаж байсан хүмүүсээс энэ талаар Д.Бодоо, Д.Чагдаржав нар ялгарч байсан ба тэд бүлгэмүүдийг нэгтгэж нам байгуулахаар 1920 оны 6 сарын 20-иор (түүх бичлэгт 6 сарын 25 хэмээн хэвшсэн) болсон ЗОУ-аас тусламж хүсэх тухай асуудлыг хэлэлцсэн зөвлөгөөнөөр хэрэгжүүлэхийг чармайсан ч дэмжлэг хүлээсэнгүй. Тэдний улс төрийн нам байгуулах оролдлого ЗОУ, Коминтерний зүгээс дэмжлэг хүлээнээр Эрхүүд тусламжийн асуудлаар хүрэлцэн очсон хоёр бүлгэмийн долоон төлөөлөгч улс төрийн нам байгуулах тухай тохиролцоонд хүрэхэд багагүй нөлөө үзүүлжээ. Гэвч тэдний нам байгуулах зорилтоо ажил хэрэг болгоход гамин болоод цагаан цэргийн улмаас Монгол оронд үүссэн нөхцөл байдал уг ажилд бэрхшээл учруулж, эцэст нь хилийн гадна 1921 оны 3 сард Монгол Ардын Нам мэндэлсэн байна.

Түлхүүр үг: Гадаад Монголын Автономит эрх, Тангарагт нөхөд, Консулын дэнжийн бүлгэм, Коминтерн.

Монгол Ардын Намын түүхийн судалгаанд тус намын үүслийн тухай асуудал чухал байр эзэлж чамгүй судлагдсан билээ. Гэвч нууц бүлгэмүүд хэрхэн нэгдэж улс төрийн нэг хүчин болсныг дахин нягтлах, уг үйл явцын үе шат, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулах шаардлага байсаар байна.

Хятадын эрх баригчид 1918 оны эхээс Гадаад Монголын бие даасан байдлыг устгах оролдлогоо дахин сэргээсэн нь Халхын Хүрээнд мөн оны дундуур С.Данзан нарын “тангарагт нөхөд”¹ оны сүүлээр Консулын дэнжийн бүлгэм үүсэх гол хүчин зүйл болов. Тангарагт нөхдийн нэг С.Данзан, Консулын дэнжийн бүлгэмийн Д.Бодоо нар хоорондоо эчнээ танилууд байсан ба Д.Бодоо урьд таних С.Данзаны гэрт хоёр удаа очиж тухайн үеийн улс төрийн хэрэг явдлын

1 Алтанбагана А, Тангарагт нөхөд-Зүүн Хүрээний бүлгэмийн үүсэл болох нь. – Acta Historica. Tom. IX. Fasc.26, УБ.,2008 т.200-207.

талаарх түүний санаа бодлыг туршин асууж, өөртэй нь үзэл бодол нэг хүмүүс буй эсэхийг лавласан байдаг. Харин С.Данзан харийн түрэмгийллийн эсрэг Д.Догсом, Ө.Дэндэв нартай “тангарагт нөхөд” болон тэмцэж буйгаа Д.Бодоод танилцуулсангүй. Зөвхөн нөхдийгөө Монголын автономит засгийн байдалд санаа зовж явдаг хүмүүс хэмээн хэлсний дагуу Д.Бодоо тэдэнтэй тус бүрчлэн уулзаж санаа бодлыг нь сонссоны дараа сая өөрийн бүлгийн нөхдөд тэдний тухай ярьжээ. Тун удалгүй Консулын дэнжийн бүлгэмээс Д.Бодоогоос гадна С.Жамъян “тангарагт нөхөд”-тэй уулзах болсон² бөгөөд үүнийг Д.Догсом “тангарагт нөхөд”-өөс “их шавь зайсан Жамъян” зэрэг хүмүүстэй бага дотнолон нөхөрлөж...намын хэргийг хүчин төгөлдөр болгохыг”³ чармайж байсан хэмээн дуртгалдаа бичжээ.

Ийнхүү 1918 оны сүүл, 1919 оны эхээр Консулын дэнжийн бүлгэм С.Данзан, Ө.Дэндэв, Д.Догсом нарыг, “тангарагт нөхөд” Д.Бодоогийн бүлгийн С.Жамъянг тус тус мэдэх болж аль аль нь танилцсан нөхдөөрөө эгнээгээ өргөтгөхийг хичээж байсан нь тэдний хооронд холбоо тогтох эхлэл болжээ. Тэдний харилцаа хувь хүмүүс хоорондын шинжийг хадгалж, харилцан биесээ туршин тандсан байдалтай байсан бөгөөд хараахан ажил хэргийн холбоо тогтоолгүй, улсынхаа тусгаар тогтнолыг хамгаалах талаар тус тусдаа арга зам хайж байв.

1919 оны намар Хятадын генерал Сюй Шү Жан Нийслэл Хүрээнд ирж Чен И-гийн явуулж байсан хэлэлцээрийг гартаа авч, Монголын эрх баригчдыг цэргийн хүчээр далайлган автономит эрхээсээ сайн дураар татгалзахыг тулган шаардаж эхэлсэн нь Хүрээний бүлгэм, Консулын дэнжийн бүлгэмийн хооронд холбоо тогтож, харийн түрэмгийллийн эсрэг хамтран тэмцэх гол нөхцөл болсон юм. Сюй Шү Жан-ы дээрх шаардлагыг хэлэлцсэн Улсын Доод хурлын хуралдаанд Консулын дэнжийн бүлгэмээс С.Жамъян, Н.Жигмэддорж, “тангарагт нөхөд”-өөс Д.Догсом, мөн тэднээс өөртөө татан нөхөрлөж байсан М.Дугаржав зэрэг хүмүүс оролцсон ба Доод хурлаас хэрхэвч Хятадын эрхшээлд орохгүй хэмээн эсэргүүцсэн ч няцаагджээ. Гадаад Монгол бие даасан байдлаа алдан Хятадын мэдэлд орох үйл явц түргэсч нөхцөл байдал ноцтой болсныг тус хуралд суусан дээрх хүмүүс нөхдөдөө танилцуулсан ба үүгээр “тангарагт нөхөд” болон Консулын дэнжийн бүлгэмийн тэмцэл улам идэвхжсэн байна. Тухайлбал, “тангарагт нөхөд” эгнээгээ өргөтгөн 10 гаруй хүн бүхий бүлгэм болж өргөжин⁴, автономит эрхээ хамгаалах тухай хэргийг Оросын консулд мэдэгдэж тусламж гуйх бичгийн эхийг зохион Богд хаантнаа айлтгаж зөвшөөрлийг олох”⁵ оролдох зэргээр зүтгэсэн байна.

Харин Консулын дэнжийн бүлгэмийнхэн тэмцлийн нэг зорилго бүхий Хүрээний бүлгэм ба Америк, Японоос тусламж эрэхийг оролдож байгаа зарим

² Чойбалсан Х, Лосол Д, Дэвид Г. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. 2 дахь хэвлэл. Хэвлэлд бэлтгэсэн Д.Даш. УБ.,1979 т.39-40

³ Догсом Д. “Ардын намыг байгуулах явдлыг анхан хэрхэн үүсгэн оролдсон тухай”.- Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. Сийрүүлж, нэмсэн 2 дахь хэвлэл. УБ.,2004 т.36-37

⁴ Алтанбагана А, Тангарагт нөхөд-Зүүн Хүрээний бүлгэмийн үүсэл болох нь. – Acta Historica. Tom. IX. Fasc.26, УБ.,2008 т.207.

⁵ Догсом Д. “Ардын намыг байгуулах явдлыг анхан хэрхэн үүсгэн оролдсон тухай”.- Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. Сийрүүлж, нэмсэн 2 дахь хэвлэл. УБ.,2004 т.38

ноёд түшмэдийн анги байгааг ярилцан “одоо бид нар тэрхүү нөхдөө танин олж хамтрах” тухай зөвлөлдөхөд С.Жамъян Хүрээний нөхөдтэй “нийлэлдэхэд ер болгоомжлох явдалгүй” хэмээхэд бусад нь түүний үгийг зөвшөөрчээ⁶. Тэрээр Хүрээний бүлгэмтэй ажил хэргийн талаар “нийлэлдэхэд ер болгоомжлох явдалгүй” хэмээн шийдэмгий үг хэлсэн нь өөрөө Консулын дэнжийн бүлгэмээс гадна Хүрээний бүлгэмд давхар харъяалагдаж тэдний үзэл бодлыг нэгэнт таньж мэдсэн байсантай нь холбоотой юм. Дээр өгүүлсэн Оросын консул Орловоос тусламж хүсэх, тусламж эрсэн бичгийг зохиох, энэ хэрэгт Богдын зөвшөөрлийг эрх зэрэг Хүрээний бүлгийн шийдвэрүүдийг түүний гэрт хэлэлцэж гаргасан ба тус хэргийг Богд хаантаа айлтган зөвшөөрлийг олохоор явсан таван хүний нэг нь С.Жамъян байв. Мөн энэ хэрэгт Консулын дэнжийн бүлгэмээс гар бие оролцсон өөр нэг хүн бол Н.Жигмэддорж байв⁷. Ийнхүү Консулын дэнжийн бүлгэмээс Хүрээний бүлгэмийн гишүүдийг таньж мэдэх, тэдэнтэй холбоо тогтоох, хамтран тэмцэх тухай шийдвэр гаргахад Д.Бодоо, С.Жамъян нар идэвхийлэн зүтгэж голлох үүргийг гүйцэтгэжээ.

Сюй Шү Жан Монголын эрх баригчдын гарын үсэг бүхий автономит эрхээс татгалзсан бичгийг авч Бээжин буцсан, удалгүй Нийслэл Хүрээнд эргэн ирж Монголын автономит эрхийг устгах гутамшигт ёслолыг үйлдсэн энэ хоёр үйл явдлын завсарт⁸ хоёр бүлгэмийнхэн “харилцан итгэлцэж...цаашид өөрсдийн ашиг завшааныг эрмэлзэхгүй дан ганц харьяат Монголын шашин үндэс ба олон түмэн ардыг гал усны зовлонгоос гэтэлгэж, амар төвшнийг олгох замыг нээгдүүлэх” зорилго дор хамтран тэмцэхээр болж, Зүүн Хүрээний Улаан сахиусны өмнө зорьсон хэргээсээ няцаж буцахгүйгээ тангарагласан байна⁹. Нууц бүлгэмүүдийн тэмцлийн зорилго, үзэл санаа нь тэдний нэгдэх үйл явцын нэг үндэс болох тул тус тангарагийн үгийн агуулга чухал ач холбогдолтой юм. С.Данзан гал усны зовлонгийн тухай тайлбарлахдаа “манай монголчууд хятад ба харгис эзэрхэг ховдог шунахай уран мэхт дайсны талхинд удаа дараагаар мэхлэгдэн орж Монголын нутагт гал усны гашуун зовлон нэмэгдэн үүсч түмэн ардын жаргалангийн үүд хаагдахад хүрсэн”¹⁰ хэмээсэн байна. Мөн М.Дугаржав энэ талаар “Хятад цэргийн түшмэл Сюй Шү Жан ирж илэрхий цэргийн сүрээр хүчирхэн эчнээ үгсээр Монголын эрх ашгийг бүрэн эзэрхэн булаан авах үест тус Монголын доод хурлаас хүлээхгүй эсэргүүцэх санал гарсан авч угсаатан харгисууд...эзэрхийлэн хамаг эрх ашиг ба гарт бүхий цэргийн зэвсэг хэрэглэлийг хүртэл Хятадад түлхэн өгсөн хирд ард олон гал усны зовлон” хүлээсэн гэжээ¹¹. Үүнээс үзвэл, тэд Хятадын түрэмгийлэл болон улс төрд өөрсдийн нөлөөгөө

⁶ Чойбалсан Х, Лосол Д, Дэмид Г. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. 2 дахь хэвлэл. Хэвлэлд бэлтгэсэн Д.Даш. УБ.,1979 т.42

⁷ Догсом Д. “Ардын намыг байгуулах явдлыг анхан хэрхэн үүсгэн оролдсон тухай”.- Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. Сийрүүлж, нэмсэн 2 дахь хэвлэл. УБ.,2004 т.38

⁸ Чойбалсан Х, Лосол Д, Дэмид Г. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. 2 дахь хэвлэл. Хэвлэлд бэлтгэсэн Д.Даш. УБ.,1979 т.42-43

⁹ Догсом Д. “Ардын намыг байгуулах явдлыг анхан хэрхэн үүсгэн оролдсон тухай”.- Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. Сийрүүлж, нэмсэн 2 дахь хэвлэл. УБ.,2004 т.39

¹⁰ Үндэсний Төв Архив. Монгол Ардын Намын баримтын төв, Ф-4, Д-1, ХН-154 т.6

¹¹ Дугаржав М. Гишүүн Дугаржав. Монгол Ардын Нам. УБ.,1925. №7-8 т.214

хадгалах, хувийн эрх ашгаа хамгаалах явцуу үзэл бүхий дотоодын эрх баригчдын буруутай үйл ажиллагаанаас Монгол нутагт гал усны гашуун зовлон үүсэн гарсан хэмээн буруушааж байжээ. Ийнхүү гал усны гашуун зовлон хэмээх нь Гадаад Монгол Хятадын эрхшээлд автсан (үүнд дотоодын харгис ноёдын эзэрхийлэл нөлөөлсөн) хүнд цаг үе мөн байна. Тиймээс нууц бүлгүүд шашин үндэс ба Монголын жирийн олон түмнийг гал усны гашуун зовлонгоос гэтэлгэх зорилт тавьж, үүний тулд харийн түрэмгийлэгчид ба дотоодын урвагч ноёд буюу угсаатан харгисуудын эсрэг тэмцэх үзэл санаан дор хамтран тэмцэх шийдвэрт хүрчээ. Энэ нь, тэр үед нууц бүлгэмүүд хувьсгалч үзэл санаа бүхий улс төрийн бүлэг бус, харин улсынхаа бие даасан байдлыг хамгаалах, түүнд хор хүргэж буй улс төр, нийгэмд бугшсан үзэгдэл, этгээдүүдтэй тэмцэх зорилго бүхий **эх оронч, шинэтгэгч үзэл бүхий хүмүүсийн нэгдэл** байсныг харуулж байна. Гэхдээ энэ тангараг нууц бүлгэмүүдийн дийлэнх гишүүдийн нийтлэг ашиг сонирхол дээр үндэслэн томьёологдсон тул уг тангарагт улс төрийн илүү гүн гүнзгий үзэл баримтлал бүхий цөөн хүмүүсийн үзэл бодол тусгагдсангүй. Тухайлбал, Д.Бодоо, Д.Чагдаржав нар 1915 оны Хиагтын гэрээгээр “Монголын автономит эрхийг тунхаглан зарласан тэр цагаас хойш...феодалын хэмжээгүй эрхт ёсны байгуулал Монголын ард түмэнд хөнөөлт шинжтэй болохыг мэдсэн ч ...тэр үеийн нөхцөлд өөрсдийгөө ил харуулж чадаагүй бөгөөд ... хятадууд Монголын автономит эрхийг устгасны дараа ардчилсан бүгд найрамдах агуулга бүхий улс төрийн мөрийн хөтөлбөр боловсруулж” түүнийгээ дэлгэрүүлж байсан¹² ба энэ тухайгаа О.И.Макстеникт өгсөн тусламжийн бичигтээ дурджээ. Тиймээс уг тангарагийн үгийг нууц бүлгэмүүдэд харьяалагдаж байсан бүх хүмүүсийн улс төрийн зорилго, үзэл бодол хэмээн хавтгайруулж болохгүй бөгөөд тус тангараг нь нууц бүлгэмүүдийн яриа хэлэлцээний үр дүн, хамтын тэмцлийнх нь анхны хөтөлбөр мөн.

Нууц бүлгэмүүд эл тангарагийг хэзээ тавьсныг тодруулвал, Сүй Шү Жаны шаардлагаар 64 зүйл бүхий гэрээнд Монголын таван яамны сайд гарын үсэг зурж, тамгаа дарахыг 1919 оны 11 сарын 17-ны орой зөвшөөрч, энэ тухай өргөдөл бичгийг гарган мөн орой генерал Сүй Шү Жанд шилжүүлсэн тухай баримтанд гарын үсэг зуржээ¹³. Сүй Шү Жан монголын ноёдын өргөдлийг хүлээн авч маргааш нь Бээжин морджээ¹⁴. Монголын ноёд өргөдөл гаргасан учир Хятад, Орос, Гадаад Монголын хооронд Монголын асуудлаар байгуулсан гэрээг хүчингүй болгосон тухай хуулийг Хятадын Бүгд Найрамдах Улсын ерөнхийлөгч 11 сарын 22-нд нийтлүүлсэн байна¹⁵. Үүний дараа Сүй Шү Жан Нийслэл Хүрээнд буцан ирж, 1920 оны I сарын 2-нд Гадаад Монголын автономит эрхийг устгах ёслолыг үйлдсэн байна. Энэ эгзэгтэй үед буюу Гадаад Монгол автономит эрхээ алдах аюул шууд тулж ирсэн 1919 оны сүүлээр нууц бүлгэмүүд сая бие биеэ бүрэн мэдэлцэж, улмаар гал усны гашуун зовлонгоос төр улс олон түмнээ гэтэлгэх зорилго дор хамтран тэмцэх тохиролцоонд хүрч чадснаар хоёр нууц бүлгэм нэгдэх явц нэг алхам урагшилжээ.

¹² Бат-Очир Л. Догсомын Бодоо (Хэлсэн, бичсэн зүйлийн түүвэр).УБ.,2001 т.12

¹³ Ширэндэв Б. Монгол ардын хувьсгалын түүх. УБ.,1999 т.114

¹⁴ Жамсранжав Б. “Ар Монголын улс төрийн дуртгал”. УБ.,1991 т.64

¹⁵ Ширэндэв Б. Монгол ардын хувьсгалын түүх. УБ.,1999 т.115

Үүний дараагаас хоёр нууц бүлгэмийн хамтын ажиллагаа Зүүн Хүрээний Улаан сахиусны өмнө тавьсан “Монголын шашин үндэс ба олон түмэн ардыг гал усны гашуун зовлонгоос гэтэлгэх” тангараг дор өрнөж эхэлжээ. Тухайлбал, тус хоёр бүлгэмийнхэн Доод хурлын нэрээр бичиг үйлдэн консул Орловт өгч Хиагтын гурван улсын гэрээгээр хүлээсэн Оросын үүргийг сануулах замаар тусламж эрэх, ухуулах бичиг бичиж олны газар наах, намын нөхдийг элсүүлэн олон болгох, Сүй Шү Жан, Г.Бадамдорж нарыг хөнөөхийг сэдэвлэн оролдох зэргээр хамтран тэмцсэн байна. Хэдийгээр нууц бүлгэмүүд ийнхүү хамтран тэмцэж байсан ч тэдний ажил хэрэг бүрэн нэгдээгүй байв. Тухайлбал, Хүрээний бүлгэм Оросоос тусламж авах ажлыг бие даан үргэлжлүүлж байв. Тэд Оросын консулын “Богд хааны тамгатай бичиг байх болбоос Засгийн газраа уламжлан нэвтрүүлж болно” гэсний дагуу тус бүлгийн таван хүн хааны ордонд хүрч тэндээс С.Данзан, Д.Догсом нар Богд хаанд бараалхан Орос улсаас тусламж гуйх бичигт тамга даруулахыг оролдсон ч хаан тэдний хүсэлтийг хойшлуулж байв¹⁶. Мөн Хүрээний бүлгэм “аравдугаар оны цагаан сард нөхөр Данзан, Сүхбаатар хоёрыг Хиагт хотноо явуулсан”¹⁷ Консулын дэнжийн бүлэг мэдээгүй ба энэ талаар тэд “зам нэвтэрч чадалгүй эгэж ирсэн хүмүүс байна шүү”¹⁸ хэмээн ярилцаж байв. Мөн Хүрээний бүлгэм энэхүү явдлын дараа Оросын харьяат М.И.Кучеренко, Я.В.Гембаржевский нартай Консулын дэнжийн бүлгээр дамжуулан танилцсан байна. [Догсом Д, 2004, т.47] Мөн Хүрээний бүлгийн Д.Догсом, М.Дугаржав нар Гандангийн гавж лам Дамдинсүрэн, Зүүн Хүрээний зурхайч Чүлтэм, ловон Цэрэндорж нараар ажил хэргээ бүтэмжтэй байх, эсэх талаар үзүүлсэн бол мөн бүлгийнхэн Вангай аймгийн Гүтэмбэ ламаар мэргэ төлөг тавиулах зэрэг ажлыг дангаар явуулжээ. Ийн нууц бүлгэмүүд зарим ажил хэргээ зөвлөлдөж хамтран гүйцэтгэж байсан ч тус тусдаа бие даасан үйл ажиллагааг өрнүүлсээр байлаа. Энэ нь хоёр бүлгэм бүрэн нэгдээгүй, харин төр улсынхаа бие даасан байдлыг сэргээх үүднээс ажил хэргээ тодорхой хэмжээнд нэгтгэж хамтран тэмцэж байсныг харуулж байна.

Нууц бүлгэмүүдийг нэгтгэн улс төрийн нам байгуулах эхний оролдлого 1920 оны 6 сарын 20-доор болсон байна. 1920 оны 6 сарын 25-нд нууц бүлгэмүүдийн өргөтгөсөн хурал болж түүгээр нэгд, ЗОУ-аас тусламж эрх тухай, хоёрт, түүнийг ямар субъектын нэрийн өмнөөс хүсэх, гуравт, эл хэрэгт хэн ямар үүрэгтэй оролцох тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэжээ. И.А.Сорокиковын бичсэнээр бол эхний асуудлыг урьдчилан 1920 оны 6 сарын 20-ний шөнө Монголын хувьсгалт байгууллагын (нууц бүлгэмийн-А.А) арван удирдагч, Хүрээн дэх Оросын хувьсгалт хорооны төлөөлөгчид хамтран хэлэлцэж Орос улсаас тусламж авах хэргээр нууц бүлгэмүүд төлөөлөгчөө илгээхээр тогтсон байна. Энэ шийдвэр эл өргөтгөсөн хурлаар дэмжигджээ.

¹⁶ Догсом Д. “Ардын намыг байгуулах явдлыг анхан хэрхэн үүсгэн оролдсон тухай”.- Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. Сийрүүлж, нэмсэн 2 дахь хэвлэл. УБ.,2004 т.40-42

¹⁷ Догсом Д. “Ардын намыг байгуулах явдлыг анхан хэрхэн үүсгэн оролдсон тухай”.- Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. Сийрүүлж, нэмсэн 2 дахь хэвлэл. УБ.,2004 т.47

¹⁸ Чойбалсан Х, Лосол Д, Дэмид Г. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. 2 дахь хэвлэл. Хэвлэлд бэлтгэсэн Д.Даш. УБ.,1979 т.42

Дараагийн асуудал буюу тусламжийг хэний нэрээр хүсэх асуудлыг хэлэлцэх үеэр нууц бүлгэмийнхний үзэл санааны зөрчил ил гарчээ. Х.Чойбалсан энэ тухай бичихдээ “Манай ардын намын бүх гишүүд улаан Орос улсаас тусламж гуйх тухай бүгдээр нэгэн саналтай байсан боловч чухамхүү тусламжийг гуйхад ардын намын тамгатай бичиг хэрэгтэй юу? Богдын тамгатай бичиг хэрэгтэй юу? гэсэн зөрөлдөөн бидний дунд гарсан...энэ хоёр хэсэг хоорондоо удаанаар маргалдан тэмцэлдэж, эцэст би, Данзаны хамт тусламж гуйх хэний ч бичиггүй...Орос улсад явахаар мордов”¹⁹ хэмээсэн байна.

Энэ нь тус зөвлөгөөн дээр нууц бүлгэмүүд тусламжийг хэний нэрээр хүсэх талаар зөрөлдсөнөөс ямар нэг тусламжийн бичиг гаргаж чадаагүйг харуулахын зэрэгцээ Б.Бодоо, Д.Чагдаржав зэрэг хүмүүс өөрийн Консулын дэнжийн бүлгэмийн нөгөө нэр болох Ардын намын нэрээр тусламж гуйх санал гаргасныг нууц бүлгэмүүдийн гишүүдийг Ардын намд нэгтгэх гэсэн оролдлого гэж үзэж болох юм. Гэвч тус зөвлөгөөнөөр тэдний санал төдий л дэмжлэг олоогүй байна. Гэвч Д.Бодоо, Д.Чагдаржав нар нам байгуулах оролдлогоосоо буцсангүй, Монгол Ардын Нам гэсэн бичиг бүхий тамга үйлдэж өөрсдийн хүрээнд намаа үүсгээд зогсохгүй ЗОУ-аас тусламж олохоор одохдоо “Монголын ард түмэн ба Гадаад Монголын Ардын намын төлөөлөгчдийн бичиг” хэмээх тусламжийн бичиг бичиж, зам зуурт О.И.Макстеникт гардуулжээ. Тэдний тусламжийн бичиг дэх 6 сарын 25-ны нууц бүлгэмүүдийн зөвлөгөөн, түүнээс гарсан тохиролцооны талаар дурдагдсан товч зүйл нь дээрх таамаглалыг бататгаж байна. Тэрхүү тусламжийн бичигт “Монгол орны бие даасан байдлыг сэргээхэд...хуучныг баримтлагч үндэсний үзэлт ноёдын ба жижиг түшмэдийн нам (Хүрээний бүлэг-А.А) хятадын эзэрхэг түрэмгий нарын эсрэг нэгдэн тэмцэх санал тавьсанд Ардын нам (Консулын дэнжийн бүлэг-А.А) үндэсний бие даасан байдлын төлөө тэмцэлдээ амжилт олохын үүднээс...Зөвлөлт улсад хандах болзолтойгоор уг саналыг хүлээн авсан” хэмээжээ²⁰. Тус бичгээс дараах зүйлүүдийг дам байдлаар тодруулж болох байна. Нэгт, нууц бүлгэмүүд тус зөвлөгөөнөөр хэлэлцсэн гол асуудал ЗОУ-аас хүсэх тусламжийн хэрэг байснаас бус нам байгуулахад чиглэгдсэнгүй. Хоёрт, нууц бүлгэмүүд тус зөвлөгөөнөөр тусламж гуйх улс, тусламж авах зорилгын талаар хэлэлцэхэд Д.Бодоо, Д.Чагдаржав нар “ардчилсан бүгд найрамдах” агуулга бүхий улс төрийн мөрийн хөтөлбөрөө тус зөвлөгөөн дээр дэвшүүлсэн байх магадлалтай байна. Энэ нь Ардын нам үндэсний эрх чөлөөний тэмцэлд амжилт олох үүднээс нөгөө бүлгэмүүдийн саналыг хүлээн авсан гэснээс мэдэгдэнэ. Харин тус зөвлөгөөнөөс гарсан шийдвэрт Д.Бодоо, Д.Чагдаржав нарын улс төрийн мөрийн хөтөлбөрийн үзэл санаа тусгагдаагүй байх бөгөөд үүнд тэд сэтгэл дундуур байсан нь тус бичгээс ажиглагдаж байна. Нөгөө талаар Д.Бодоо, Д.Чагдаржав нар Ардын намын нэрийн өмнөөс тусламжийн бичгийг үйлдэх гэсэн нь санамсаргүй хэрэг биш бөгөөд үүнийг тэдний “ардчилсан бүгд найрамдах” агуулга бүхий мөрийн хөтөлбөртэй холбож үзэх нь зүйтэй. Гуравт, Ардын намын тусламжийн бичигт нууц бүлгэмүүд намд нэгдсэн тухай огт дурдаагүйгээс гадна уг бичиг Консулын

¹⁹ Чойбалсан Х, Лосол Д, Дэмид Г. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. 2 дахь хэвлэл. Хэвлэлд бэлтгэсэн Д.Даш. УБ.,1979 т.385

²⁰ Бат-Очир Л. Догсомын Бодоо (Хэлсэн, бичсэн зүйлийн түүвэр).УБ.,2001 т.12-13

дэнжийн бүлгэмийн нөгөө нэрээр хаяглагджээ. Энэ бүхнээс ЗОУ-аас тусламж эрх асуудлыг хэлэлцсэн нууц бүлгэмүүдийн хамтарсан зөвлөгөөний үеэр Д.Бодоо, Д.Чагдаржав нар улс төрийн мөрийн хөтөлбөрөө дэвшүүлэн Ардын намд нууц бүлгэмүүдийн гишүүдийг нэгтгэж, тус намын нэрээр тусламж эрэхийг оролдсон боловч энэ нь бүтэлгүйтсэн тул тэд тус намыг цөөн хүний хүрээнд үүсгэн намын тамгыг үйлдэж, Ардын намын нэрээр ЗОУ-аас тусламж гуйсан бичиг үйлдэж авч явсан хэмээн үзэж болох байна.

Үүнээс үзвэл, 1920 оны 6-р сарын нууц бүлгэмүүдийн өргөтгөсөн зөвлөгөөн дээр Д.Бодоо, Д.Чагдаржав нар нууц бүлгэмүүдийн гишүүдийг өөрсдийн улс төрийн зорилго дор нэгтгэж нам байгуулах гэсэн анхны оролдлогыг хийжээ. Д.Бодоо, Д.Чагдаржав нарын улс төрийн нам байгуулах анхны энэ оролдлогын цаана нууц бүлгэмүүдийн гишүүдийг улс төрийн нэг хүчинд зангидах, улмаар тус улс төрийн хүчний нэрээр ЗОУ-аас тусламж авч улсынхаа тусгаар байдлаа сэргээхээс гадна өөрсдийн боловсруулж байсан “ардчилсан бүгд найрамдах” агуулга бүхий улс төрийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх нөхцөл бололцоог гартаа оруулах гэсэн зорилго нуугдаж байв. Зөвлөгөөнд оролцогсод тэдний саналыг хүлээн аваагүй бөгөөд энэ нь Д.Бодоо, Д.Чагдаржав нарын тодорхойлсноор “хуучныг баримтлагч үндэсний үзэлт ноёдын ба жижиг түшмэдийн” бүлгэмийн үзэл санаатай зөрчилдсөнөөс болжээ. Өөрөөр хэлбэл, Д.Бодоо, Д.Чагдаржав нарын дэвшүүлсэн Монголд ардчилсан бүгд найрамдах дэглэм тогтоох тухай улс төрийн хөтөлбөрийг нууц бүлгэмүүдийн гишүүдийн дийлэнх хэсэг хүлээн авахад бэлэн биш байсан бөгөөд зөвхөн улсынхаа бие даасан байдлыг сэргээх болон хэмжээгүй эрхт хаант засаглал, угсаа залгамжлах ёсны хүрээнд шинэтгэл хийх гэсэн байр суурь бүхий байснаас тэдний улс төрийн нам байгуулах эхний оролдлого амжилт олоогүй байна.

Тиймээс тус зөвлөгөөнөөр нууц бүлгэмүүд ямар нэг намд нэгдээгүй бөгөөд тусламж гуйх субъектын талаар ч бүрэн тохиролцож чадаагүйгээс Эрхүүд Ардын нам ба Богд хааны тамга бүхий хоёр тусламжийн бичиг хүрчээ.

Уг асуудалтай холбогдуулан нэмэн хэлэхэд, Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын “Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх” зохиол дахь 6-р сарын өргөтгөсөн зөвлөгөөнөөр нууц бүлгэмүүд МАН-д нэгдсэн гэх мэдээ нь түүхийн бусад сурвалжуудтай төдийгүй Х.Чойбалсаны илтгэлд буй өмнө өгүүлсэн мэдээтэй зөрчилдөж байгааг тэмдэглэе. Мөн Эрхүүгийн хэлэлцээрийн үеэр Ардын намын төлөөлөгчид тус намд Хүрээний бүлгэм нэгдээгүй байгааг мэдэгдсэн байдаг билээ²¹. Үүнээс үзвэл, Д.Бодоо, Д.Чагдаржав нарын цөөн хүний хүрээнд Ардын намыг үүсгэсэн явдлыг Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын зохиолд хоёр нууц бүлгэм нэгдсэн мэтээр дэвэргэсэн гэж болохоор байна.

Ардын нам, Хүрээний бүлгэм хоёр нэгдэн улс төрийн нэг хүчин болох гол хэлэлцээр Эрхүүд тусламжийн хэргээр очсон Д.Бодоо, Д.Чагдаржав, Х.Чойбалсан, С.Данзан, Д.Догсом, Д.Сүхбаатар, Д.Лосол нарын дунд болж шийдэлд хүрч чадсан юм. Эрхүүгийн хэлэлцээрийн эхний уулзалтаар ЗОУ-ыг төлөөлж хэлэлцээг явуулсан эрх бүхий хүмүүс Монголоос ирсэн төлөөлөгчдөд хандан мэдэгдэл

²¹ Коминтерн ба Монгол. (Баримтын эмхтгэл). УБ.,1996 т.11

хийсэн бол тусламжийн асуудлаар юуны түрүүнд төлөөлөгчдийн нэг хэсэг болох Ардын намын хүмүүстэй тусгайлан хэлэлцээ хийжээ. Ардын намын хүмүүст Д.Бодоо, Д.Чагдаржав, Х.Чойбалсан нар багтаж байсан бололтой бөгөөд тэднээс уулзалтын үеэр тус нам үзэл суртал, зохион байгуулалтын талаар төлөвшиж чадаагүйг тэмдэглээд “Монгол дахь шашин төрийг хослон баригч феодалын байгууллыг устгаж, ардчилсан дэглэм тогтоох”-ыг Ардын намын зорилт хэмээн тодорхойлжээ²².

Энэ үед ОК(б)Н-аас Монголд тавьж байсан нэг зорилт нь тус оронд үүссэн үндэсний эрх чөлөөний тэмцлийн урсгалуудыг бат тогтвортой намын хэлбэрт оруулах,²³ улмаар тэрхүү нам засгийн эрхийг гартаа авах явдал байв. ЗОУ-ын төлөөлөл дээрх чиг шугамыг баримтлан Монголын төлөөлөгчидтэй хэлэлцээр явуулж, өөрийн нөхцлүүдийг тэдэнд тавьжээ. Энэ тухай Х.Чойбалсан нар бичихдээ “Гапоноос...энэхүү богдын тамгат бичгийг хүлээн авъя. Гэвч та нөхдөөс чухамхүү зорьсон төв итгэл хүсэл эрмэлзлэг юу болох, мөн тусламжийг аваад ямар засаг байгуулах, мөн гадаадын дайсантай эсэргүүцэхэд ямар арга төлөвлөгөө, ямар зүйлийн хүчин зэвсэг эгээрих зэргийг дэлгэрэнгүйгээр тайлбарлан гаргасан илтгэл гаргаж өгвөл зохино...эрхэм нөхөд хэргийн үүсгэл төгсгөл зэргийг гүнээ анхаарч, чухамхүү эрмэлзэх саналыг эрс шийдвэртэйгээр гаргавал танай зорьсон хэрэгт дөхөмтэй болж чадахыг” сануулсан байна²⁴.

Энэ нь тусламжийн асуудлыг тавихад Богд хааны тамга бүхий бичгээр бус үндэсний эрх чөлөөгөө олж засгийн эрхийг авах зорилт бүхий намын баримт бичиг зайлшгүйг хэлсэн хэрэг бөгөөд үүний улмаас Эрхүүд Ардын нам, Хүрээний бүлгэмийн төлөөлөгчид тусламжийн бичгийг намын нэрийн өмнөөс боловсруулах шаардлагатай болсон юм. Үүгээр хоёр бүлгэмийн төлөөлөл болсон долоон хүн хамтын тэмцлийнх нь анхны мөрийн хөтөлбөр болсон “дан ганц харьяат Монголын шашин үндэс ба олон түмэн ардыг гал усны зовлонгоос гэтэлгэж, амар төвшнийг олгох замыг нээгдүүлэх” хэмээх тангарагийн үгээ Эрхүүд шинэчлэн томъёолох шаардлагатай болжээ. Өөрөөр хэлбэл, уг тангараг дор нууц бүлгэмүүд хамтран ажиллах нөхцөл Эрхүүд Зөвлөлт Оросын төлөөллөөс тавьсан дээрх шаардлагаар хаагдаж, монголчууд тэмцлийн зорилт, шинж чанар, тусламж хүсэж буй субъектэй илүү тодруулах шаардлагатай болжээ.

Ийнхүү Монголын төлөөлөгчид И.Ф.Гапоны сануулгыг харгалзан ЗОУ-аас тусламж авч буй зорилго, хүрэх үр дүн, арга зам зам, гүйцэтгэх хүчин юу болох зэргийг дахин томъёолсон тусламжийн бичгийг намын нэрийн өмнөөс хамтран бичиж хэлэлцээрийг үргэлжлүүлэх нөхцлийг хангах асуудал тэдний өмнө тавигдав. Эл асуудлыг хэлэлцэх үед Монголын төлөөлөгчид санал хуваагдсанаас гудамжаар хоёр хуваагдан явахад хүрч байв. Энэ нь Д.Бодоо, Д.Чагдаржав нарын улс төрийн нам байгуулж Монголын нийгэм-улс төрийн байгууллыг өөрчлөх гэсэн, Хүрээний бүлгэмийн Монголын нийгэм-улс төрийн тогтолцоог засаж тордох замаар заримдаг шинэчлэлт хийх гэсэн тэдний өмнөө тавьсан зорилтууд

²² Коминтерн ба Монгол. (Баримтын эмхтгэл). УБ.,1996 т.10

²³ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг. (1920-1932). Баримтын эмхтгэл. I боть. УБ.,2002 т.21

²⁴ Чойбалсан Х. Сүхбаатар бол Ардын хувьсгалт намын жолоодогч бөгөөд түүний зохион байгуулагч мөн. - Илтгэл ба өгүүллүүд. Боть 3. УБ.,1953 т.385

харилцан адилгүй байснаас үүдэлтэй бөгөөд Ардын нам, Хүрээний бүлгэмийн аль аль нь тусламжийн асуудлыг өөрсдийн зорилтын хүрээнд ЗОУ-д тавьж дэмжлэг хүлээхийг эрмэлзэн өрсөлдөж байжээ.

Харин ОК(б)Н-ын Монголд үүссэн нууц бүлгэмүүдийг бат тогтвортой намын хэлбэрт оруулах гэсэн байр суурь, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн монголчуудад тавьсан шаардлагууд нь Д.Бодоо, Д.Чагдаржав нарын дэвшүүлж байсан ардчилсан бүгд найрамдах засаглал тогтоох үзэл санаа, түүнийг хэрэгжүүлэх улс төрийн нам байгуулах (Хүрээний бүлгэмийг нэгтгэж) оролдлогод дэмжлэг болсон юм. И.Ф.Гапоны шаардлагыг Ардын нам, Хүрээний бүлгэмийн төлөөллүүд хэлэлцэж тохиролцоонд хүрснээр ОК(б)Н-ын Төв Хорооны Сибирийн товчооны Дорно дахины ард түмний секцийн Монгол-Түвэдийн хэлтэст тусламжийг хэний нэрээр хүсэх, Монголд өрнөх хувьсгалын зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замыг дэлгэрэнгүй бичсэн бичгийг Монгол-Түвэдийн хэлтэст гаргаж өгчээ. Уг баримт бичиг боловсрогдож гарснаар нууц бүлгэмүүд улсынхаа тусгаар тогтнолыг сэргээх хамтын тэмцлээсээ халин гарч, Монгол Ардын Нам хэмээх улс төрийн хүчинд нэгдэх хэлэлцээрт хүрч чадсан байна. Тодруулбал, энэхүү баримт бичгээр ЗОУ-аас авах тусламжийг Ардын намын нэрээр авах, Монголын төрийг автономит хэмжээнд сэргээх, Жибзундамба хутагтыг хэмжээтэй эрхтэй хаанд өргөмжилж, засгийн эрхийг удахгүй байгуулагдах МАН авах, ноёдын их баргийг аажим эвдэх замаар улс төр, нийгэм-эдийн засгийн шинэтгэл хийх, гадаад улс орнуудын дэвшилт ёсыг дагаж, жирийн олны эрх ашгийг хамгаалсан бодлого явуулах, хойд, урд хөрш улсын Ардын намуудтай холбоо тогтоож тэдгээр намуудтай хамтарч ажиллах зэрэг олон зүйлээр нууц бүлгэмүүдийн удирдлага тохиролцож чаджээ²⁵. Мөн Ардын нам, Хүрээний бүлгэм зохион байгуулалтын хувьд нэгдэх нь зайлшгүй болж, намыг удирдах гол хороог Нийслэл Хүрээнд, салбар хороодыг Монголын төв, баруун, зүүн, хойд нутгуудын голлох төв газруудад үүсгэхээр уг бичигт заажээ. Ингэж улс төрийн шинэ зорилтод Ардын нам, Хүрээний бүлгэмийн хамтын тэмцэл захирагдах болсноор түүний үзэл санааны төлөвлөлийн шинэ үе эхэлж, улс төрийн нэг хүчинд нэгдэх сүүлийн алхам болжээ.

Өөрөөр хэлбэл, уг баримт бичгээр тэд *үндэсний тусгаар тогтнолоо олохын зэрэгцээ засгийн эрхийг улс төрийн намаар дамжуулж гартаа авах, Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн хуучин тогтолцоог халах зорилт бүхий улс төрийн хүчин МАН-д нэгдэх тухай түүхэн шийдвэрийг гаргасан байна. Энэ хүртэл нууц бүлгэмүүд Монголын шашин, үндэс, олон түмнийг харийн эрхшээлээс ангижруулах буюу “гал усны зовлонгоос гэтэлгэх” зорилго дор хамтран тэмцэж ирсэн юм.*

ОК(б)Н-ын Төв Хорооны Сибирийн товчооны Дорно дахины ард түмний секцийн Монгол-Түвэдийн хэлтэст хэлтэст гаргасан тусламжийн энэ бичгээр нууц бүлгэмийн дийлэнх гишүүдийн автономит эрхээ сэргээх болон хаант засгийн хүрээнд заримдаг шинэтгэл хийх зорилт хойно хоцорч Д.Бодоо, Д.Чагдаржав нарын үзэл баримтлал дэс дараалсан арга хэмжээний үр дүнд хэрэгжихээр болжээ. Ийнхүү Консулын дэнжийн бүлгэм, Хүрээний бүлгэм улс төрийн нэг зорилго дор нэгдэн НАМ болох тухай тохиролцоонд хүрэхэд Д.Бодоо,

²⁵ Коминтерн ба Монгол. (Баримтын эмхтгэл). УБ.,1996 т.20-21

Д.Чагдаржав нарын “ардчилсан бүгд найрамдах” үзэл баримтлал чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Нөгөө талаар тэдний өмнөө тавьсан тэмцлийн зорилт 1921 оны хувьсгал “ардчилсан” шинжийг олоход чухал нөлөөг үзүүлжээ.

Ардын нам, Хүрээний бүлгэмийн улс төрийн нам байгуулах тохиролцоо 1921 оны 3 сарын 3-нд сая бүрэн биелж, намын хөтөлбөр, дүрэм, удирдах бүрэлдэхүүнийг шийдвэрлэснээр Монголын ууган улс төрийн хүчин Монгол Ардын нам мэндэлжээ. 1920 оны 8 сарын 29-нд Монгол-Түвэдийн хэлтэст гаргасан бичигт тус нам засгийн эрхийг авах зорилт тусгагдсан бөгөөд үүнд чиглэсэн дараагийн алхам болох Д.Чагдаржаваар толгойлуулсан МАН-ын Түр Засгийн газрыг байгуулснаар Монгол орны түүхийн нэгэн шинэ хуудас нээгдэх нөхцөл хангагджээ.

Энэ бүхний эцэст нь Монгол Ардын Намын үүсэл буюу нууц бүлгэмүүд хэрхэн нэгдсэн үйл явцыг дүгнэн хэлбэл,

Нэгд, 1921 оны 6 сарын 25-нд нууц бүлгэмүүд МАН хэмээх байгууллагад нэгдсэн, эсвэл тус нам байгуулагдсан гэх түүх бичлэгт хэвшсэн үзэл ташаа байна. Энэхүү ташаарал Х.Чойбалсан нарын “Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх” зохиолын мэдээнээс улбаатай бөгөөд үүнийг энэ үйл явдалтай холбоотой бусад сурвалж, мэдээ баримт үгүйсгэж байна.

Хоёрт, Хүрээний, Консулын дэнжийн нууц бүлгэмүүд нэгдэж улс төрийн хүчин болох үйл явц 3 үе шатыг туулсан байна. Нууц бүлгэмүүд харилцан бие биеэ мэдэлцэж, тэдний дунд холбоо тогтсон үе. Энэ нь 1918 оны төгсгөл, 1919 оны эхэнд холбогдоно. Дараагийн шат болох нууц бүлгэмүүд улсынхаа тусгаар байдлыг хамгаалах зорилго дор хамтран тэмцэж байсан үе 1919 оны төгсгөлөөс 1920 оны 8 сарын сүүл хүртэл үргэлжилнэ. Төгсгөлийн шатанд нууц бүлгэмүүд улс төрийн нэг хүчинд нэгдэх шийдвэрт 1920 оны 8 сарын 29-нд хүрч, эл шийдвэр 1921 оны 3 сарын 3-нд намын анхдугаар их хурал хуралдсанаар хэрэгжжээ.

Abstract: *This article reviews the formation of the Mongolian People's Party through a merger of the Urga and Consular Hill groups and the factors that influenced this event.*